



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/277

Улаанбаатар хот

“ШУТИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам”-д
нэмэлт өөрчлөлт оруулах, “ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн
үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, Ахмад насны тухай хуулийн 9 дүгээр зүйл, 14 дүгээр зүйлийн 14.7, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Ахмадын сан байгуулан ажиллуулах журам, ШУТИС-ийн дүрмийн 4.9.15, 4.9.16, ШУТИС-ийн Ректорын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. ШУТИС-ийн 2025 оны цалингийн нийт сангийн 0.4 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулсугай.

3. Ахмад настны хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан “ШУТИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.1.17 “ШУТИС-д ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настныг гэрээгээр ажиллуулж болох ба гэрээт багш, зөвлөх профессор, судалгааны хүрээлэн, төвийн захирал, эрдэм шинжилгээний ажилтан, ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн даргаар ажиллуулах насны дээд хязгаар 70, бусад гэрээт ажилтны насны дээд хязгаар 65 нас байна.” гэсэн заалтыг “ШУТИС-иас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настныг зохих хууль, тогтоомжийн дагуу ажиллуулж болно” гэж өөрчлөн найруулсугай.

4. Шинэчлэн батлагдсан “ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг танилцуулж хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга (Б.Түмэндэлгэр)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн Ректорын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/226 дугаартай тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хүчингүйд тооцсугай.

6. Энэхүү тушаалыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

РЕКТОР



Т.НАМНАН

367041634

ШУТИС-ийн ректорын 03-ийн өдрийн 09-дугаар сарын
03-ний өдрийн 09-дугаар тушаалын хавсралт



ШУТИС-ИЙН АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. ШУТИС-ийн ахмадын зөвлөл (цаашид “Ахмадын зөвлөл” гэх) нь тус их сургуулиас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сургуулийн хэмжээнд төлөөлөх байгууллагыг хэлнэ.
- 1.2. ШУТИС-д ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан бүр Ахмадын зөвлөлийн гишүүн байна.
- 1.3. Энэхүү журмын зорилго нь ШУТИС-ийн ахмадын зөвлөлийн бүтэц, үйл ажиллагаа, ахмадын сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт болон зарцуулалтыг тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.4. Ахмадын зөвлөл нь хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд үйл ажиллагаанд хэрэглэгдэх албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

ХОЁР. АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1. Ахмадын зөвлөл нь ШУТИС-ийн хүний нөөцийн асуудал хариуцсан захиргааны нэгжид харьяалагдана.
- 2.2. Ахмадын зөвлөлийн хамтын удирдлага нь дарга, орлогч дарга, бүрэлдэхүүн, салбар сургуулийн Ахмадын салбар зөвлөлийн дарга, төлөөллөөс бүрдсэн сайн дурын 15 хүртэлх сондгой тооны тэргүүлэгчдээс бүрдэнэ.
- 2.3. Ахмадын зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Ректорын тушаалаар томилогдсон Зөвлөлийн дарга удирдана.
- 2.4. Ахмадын зөвлөлийн дарга нь ШУТИС-ийн профессорын албан тушаалын цалингийн 50 хувиар цалинжих ба кредитийн заавал биелүүлэх ноогдолгүй байна.
- 2.5. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн Ахмадын салбар зөвлөлийн даргыг тухайн сургуулийн Захирлын тушаалаар томилон, сар бүр 150,000 (нэг зуун тавин мянган) төгрөгийн хөлс олгоно.
- 2.6. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн ахмадын салбар зөвлөлийн дарга нараас нэг хүнийг сонгон ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн орлогч даргаар ажиллуулж болно. Ахмадын зөвлөлийн орлогч даргыг ШУТИС-ийн ахмадын зөвлөлийн даргын саналыг үндэслэн Ректорын тушаалаар томилж, сар бүр 500,000 (таван зуун мянган) төгрөгийн хөлс олгоно.
- 2.7. Ахмадын зөвлөл нь жилийн ажлын төлөвлөгөөг санхүүгийн жилээр харьяалах захиргааны нэгжтэй зөвшилцөн боловсруулж, холбогдох зардлыг ШУТИС-ийн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.
- 2.8. Ахмадын зөвлөл нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт болон Ахмадын сангийн санхүүгийн үр дүнгийн тайланг ШУТИС-ийн захиргааны холбогдох нэгжүүдтэй хамтран боловсруулж, Ректорын зөвлөлд тайлагнана.

ШУТИС-ийн ректорын 2025 оны 09 дугаар сарын
03 ний өдрийн 7 дугаар тушаалын хавсралт



ГУРАВ. АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Ахмадын зөвлөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
 - 3.1.1. Их сургуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд ШУТИС-ийн захиргаа, бүтцийн нэгжүүд, бүрэлдэхүүн, салбар сургууль, Оюутны холбоо, Төгсөгч дэмжигчдийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;
 - 3.1.2. Ахмадын зөвлөлийн гишүүний эрх ашгийг хамгаалан тэдэнд дэмжлэг, туслалцаа үзүүлж, тэдний санал санаачилгыг дэмжин ажиллах;
 - 3.1.3. Ахмадын зөвлөлийн гишүүний чөлөөт цаг, эрүүл мэндийн үйл ажиллагааг дэмжиж, урлаг, спортын тоглолт, аяллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
 - 3.1.4. Багш, ажилтныг соён гэгээрүүлэх сургалт, арга хэмжээнд Ахмадын зөвлөлийн гишүүнийг оролцуулах;
 - 3.1.5. Цагаан сар, Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан мөн Нас тэгширсэн (эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас) ойгоор Ахмадын зөвлөлийн гишүүнд хүндэтгэл үзүүлэх ажиллагааг ШУТИС-ийн захиргаатай хамтран зохион байгуулах;
 - 3.1.6. Ахмадын зөвлөлийн гишүүнд ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд заасан тэтгэмж, буцалтгүй тусламж олгох асуудлыг зохих журмын дагуу уламжлах;
 - 3.1.7. Ахмад настныг ШУТИС-ийн болон төрийн дээд одон, медаль, шагналд тодорхойлох, санал санаачилга гаргах;
 - 3.1.8. Насны ой, бусад тэмдэглэлт үйл явдлуудад талархал илэрхийлэх, хүндэтгэл үзүүлэх, хөдөлмөрийн алдрыг түгээн дэлгэрүүлэх, тэдний эрдэм оюун, ур ухаан, ажлын ариун баялаг арга туршлагаас суралцуулах ажлыг санаачлан хэрэгжүүлэх;
 - 3.1.9. Монголын ахмад багш нарын холбоо, бусад байгууллагатай хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх.

ДӨРӨВ. ШУТИС-ИЙН АХМАДЫН САН

- 4.1. ШУТИС нь Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасан мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулна.
- 4.2. Ахмадын сангийн хэмжээг ахмад настны тоо, их сургуулийн төсөв, санхүүгийн байдлаас хамааруулан хоёр жилд нэг удаа ШУТИС-ийн Ахмадын зөвлөлтэй зөвшилцөн, Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 4.3. Ахмадын сангийн хөрөнгө нь ШУТИС-ийн төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг байна.
- 4.4. ШУТИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн, салбар сургууль, нэгжүүд нь ахмадын санд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусгана.
- 4.5. Ахмадын сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:
 - 4.5.1. ШУТИС-ийн цалингийн нийт сангийн тодорхой хувиар ахмадын санд төвлөрүүлсэн хөрөнгө;
 - 4.5.2. ахмадын сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл хөрөнгө;



- 4.5.3. гадаад, дотоодын байгууллага болон иргэдээс санд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламж;
- 4.5.4. бусад эх үүсвэр;
- 4.6. Ахмадын сангийн хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна. Үүнд:
- 4.6.1. ШУТИС-д 15-аас доошгүй жил идэвх зүтгэлтэй ажилласан ахмад настан хүнд өвчин (эмнэл зүйн, лабораторийн аргаар мэргэжлийн байгууллагаар тодорхойлсон дүгнэлт)-ийн улмаас эх орондоо болон гадаад улсад 10 сая төгрөгөөс дээш төлбөртэй эмчилгээ хийлгэх тохиолдолд эмчилгээний зардалд зориулж ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журам, Хамтын гэрээний жишгийг баримтлан нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;
- 4.6.2. ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн дарга, орлогч дарга, бүрэлдэхүүн, салбарын сургуулийн Ахмадын салбар зөвлөлийн даргын цалин, хөлс болон зөвлөлүүдийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;
- 4.6.3. Ахмадын зөвлөлийн гишүүн ШУТИС-ийн болон төрийн дээд одон, медаль, шагналаар шагнуулсан тохиолдолд холбогдох зардлыг санхүүжүүлэх;
- 4.6.4. Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгалын зүйл гардуулах;
- 4.6.5. ШУТИС-д ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмадын зөвлөлийн гишүүн нас барвал ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журам, Хамтын гэрээний жишгийг баримтлан нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт олгох;
- 4.6.6. Ахмадын зөвлөлөөс зохион байгуулж буй аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- 4.6.7. Хуульд заасан хүрээнд Ахмадын зөвлөлийн гишүүнд чиглэсэн бусад хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх.
- 4.7. Ахмадын сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын болон зориулалтын бус зардалд зарцуулахыг хориглоно.
- 4.8. Ахмадын сангаас журмын 4.6.1, 4.6.5, 4.6.6-д заасан тэтгэмж, буцалтгүй тусламж авахыг хүссэн Ахмадын зөвлөлийн гишүүн нь бүрэлдэхүүн, салбар сургуулийн Ахмадын зөвлөлд хүсэлт гаргана.
- 4.9. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн Ахмадын зөвлөл нь 4.8-д заасан хүсэлтийн талаарх саналаа ШУТИС-ийн ахмадын зөвлөлийн даргад хүргүүлнэ.
- 4.10. Энэ журмын 4.9-д заасан саналыг ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, Ректорын зөвлөлд саналаа хүргүүлнэ.
- 4.11. ШУТИС-ийн Ахмадын зөвлөлийн тэргүүлэгчдийн саналыг Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ.
- 4.12. Ахмадын сангаас санхүүжүүлэх зардлуудын хэмжээг Ректорын тушаалаар тогтооно.
- 4.13. Ахмадын сангийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хөтлөн явуулахыг ШУТИС-ийн захиргааны болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн ахлах нягтлан бодогч нар хариуцна.
- 4.14. Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, хуваарилах, төсөвлөх, төсвийн дагуу зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг санхүүгийн асуудал хариуцсан захиргааны нэгж, бүрэлдэхүүн, салбар сургууль, нэгжүүд, Ахмадын зөвлөл хамтран хүлээнэ.

ШУТИС-ийн ректорын захирагчийн 03-ий өдрийн 09-дугаар сарын 09-дугаар тушаалын хавсралт



ТАВ. БУСАД

- 5.1. Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааны мэдээллийг ШУТИС-ийн Веб сайтын Ахмадын зөвлөл цэсэд тогтмол байршуулан танилцуулна.
- 5.2. Ахмадын зөвлөлийн гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг хичээлийн жил бүрийн төгсгөлд Ректорын зөвлөлд танилцуулан үнэлүүлнэ.

-- оОо --